



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар A/532

Булган сум

┌ Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан ┐  
Их сургуулийн бакалаврын оюутнуудын сургалтын  
төлбөрт хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоол, 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" VIII/56 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай" A/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Шинхан Их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр аймгийн Засаг даргын нэрэмжит 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөр хамрагдах шалгуурыг хангаж, бакалаврын хөтөлбөрт элсэн суралцах болсон оюутнуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоход шаардлагатай 77,977,350 (далан долоон сая есөн зуун далан долоон мянга гурван зуун тавь) төгрөг, гадаад гуйвуулгын төлбөрт 160,000 (нэг зуун жаран мянга) төгрөгийг "Эрдэнэт үйлдвэр" Төрийн өмчийн үйлдвэрийн газрын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010730

Аймгийн Засаг даргын 2025 оны  
08 дугаар сарын 05 ны/ний өдрийн  
А/532 дугаар захирамжийн хавсралт



**Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан Их сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэж, Булган аймгаас 100 хувийн тэтгэлэгтэй суралцах оюутнуудын жагсаалт**

д/д	Сум , сургууль	Овог нэр	Нэр	Мэргэжил	Сургалтын төлбөр /төгрөг/
1	Баян-Агт	Мөнхбат	Урангоо	Газар зохион байгуулалт	5,233,200
2	Баяннуур	Мөнхсайхан	Агиймаа	Олон улсын аялал жуулчлал	5,233,200
3	Бугат	Сүхбаатар	Хүслэн	Олон улсын худалдаа	5,233,200
4	Бүрэгхангай	Баасандорж	Оюузаяа	Эрчим хүчний инженер	6,661,650
5	Гурванбулаг	Батгэрэл	Аззаяа	Радиологи судлал	6,341,250
6	Сайхан	Бямбадорж	Алтансүвд	Программ хөгжүүлэлт	6,661,650
7	Сэлэнгэ	Өлзийбаатар	Тэмүүлэн	Программ хөгжүүлэлт	6,661,650
8	Хишиг-Өндөр	Ганболд	Тэлмэн	Эрчим хүчний инженер	6,661,650
9	Булган 1-р сургууль	Галмэргэн	Энхжин	Дата менежмент	5,233,200
10	Хялганат	Галбадрах	Тэмүгэ	Интерьер дизайн	6,648,300
11	Булган 2-р сургууль	Эрдэнэбилэг	Даваадалай	Программ хөгжүүлэлт	6,661,650
12	Рашаант	Батболд	Анударь	Радиологи судлал	6,341,250
13	Булган	Жавхлантөгс	Нандин	Сэжон Их сургууль хүний их эмч	4,405,500
НИЙТ ДҮН					77,977,350

Монгол банкны 2025 оны 07 дугаар сарын 30-ны ханш 1KRW - 2.58 төгрөг